



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАЙГАЛЬ ОРЧИН - ЭДИЙН ЗАСГИЙН ДАНСНЫ
СИСТЕМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНС - 2021

Улаанбаатар хот
2022 он





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАЙГАЛЬ ОРЧИН-ЭДИЙН ЗАСГИЙН ДАНС

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНС - 2021

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон үгийн жагсаалт	3
НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	5
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ҮР ДҮН.....	6
2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	6
2.1.1. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР	7
2.1.2. ТЭЭВРИЙН ТАТВАР	8
2.1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР	8
2.1.4. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТАТВАР	9
2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАР, ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР.....	9
2.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАРАМТ.....	10
ДҮГНЭЛТ	11
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	14

Хүснэгтийн жагсаалт

ХҮСНЭГТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНААС ГАРАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2018-2021 он, тэрбум төгрөг	6
ХҮСНЭГТ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг	7
ХҮСНЭГТ 3. ТҮЛШНИЙ ИМПОРТ, 2018-2021 он, мянган тонн	7
ХҮСНЭГТ 4. ТЭЭВРИЙН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг	8
ХҮСНЭГТ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг	9
ХҮСНЭГТ 6. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг	9
ХҮСНЭГТ 7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАР, татварын орлогын төрөл, татвар төлөгчөөр, 2021 он	10

Зургийн жагсаалт

ЗУРАГ 1 . БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2015-2021 он	6
ЗУРАГ 2 . ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР, ТҮЛШНИЙ ИМПОРТ, 2015-2021 он (2015=100)	7
ЗУРАГ 3. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, ТЭЭВРИЙН ТАТВАР, 2015-2021 он (2015=100)	8
ЗУРАГ 4 . НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР, 2015-2021 он (2015=100)	9
ЗУРАГ 5 . ЭРЧИМ ХҮЧ, ТЭЭВРИЙН ТАТВАР, татвар төлөгчөөр, дүнд эзлэх хувиар	10
ЗУРАГ 6 . НИЙТ ТАТВАР, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, 2015-2021 он	10

Товчилсон үгийн жагсаалт

АДТ	Автобензин, дизелийн түлш
АТӨЯХ	Автотээвэр, өөрөө явагч хэрэгсэл
АХБ	Азийн хөгжлийн банк
БОЭЗДС	Байгаль орчин-эдийн засгийн дансны систем
БХАГ	Бодлого, хамтын ажиллагааны газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ҮТХ	Үндэсний тооцооны хэлтэс

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Д.Энхзаяа БХАГ-ын ҮТХ-ийн ахлах статистикч

И-мэйл: enkhzaya@nso.mn

Утас: 51-261501

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.Халиун БХАГ-ын дарга

Б.Баярмаа БХАГ-ын ҮТХ-ийн дарга

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44

Засгийн газрын III байр

Утас: 1900-1212

Факс: 11-324518

Цахим хуудас : www.nso.mn, www.1212.mn

И-мэйл: information@nso.mn

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Байгаль орчны татварын дансны үндсэн зорилго нь эдийн засаг, байгаль орчны хоорондын хамааралд Засгийн газрын гүйцэтгэх үүрэг болон байгаль орчны талаар авч хэрэгжүүлэх бодлогын суурь арга хэрэгслийг тодорхойлох, байгаль орчны татвартай холбогдох тогтвортой хөгжлийн зорилго болон ногоон хөгжлийн үзүүлэлтийг тооцох, бодлогын хэрэгжилтийг үнэлэх, байгаль орчин, эдийн засгийн дүн шинжилгээ хийх мэдээллийг бий болгоход оршино.

Байгаль орчны татварын данс нь БОЭЗДС-ийн дэд данс болох байгаль орчинтой холбогдох үйл ажиллагааны данс, түүнтэй холбогдох мөнгөн урсгалын данс болон ҮТС-тэй нягт уялдана. Байгаль орчны талаар төрөөс авч хэрэгжүүлэх бодлогын суурь мэдээлэл болж өгнө. Энэхүү данс нь байгаль орчныг хамгаалах зардлын данс байгуулахад ач холбогдол бүхий нэмэлт мэдээлэл болно.

Байгаль орчны татвар гэж байгаль орчинд сөрөг нөлөөтэй нь нотлогдсон аливаа зүйлийн биет нэгж нь татварын суурь болох татварыг ойлгоно.

Эрчим хүчний татвар (тээврийн зориулалттай түлшийг оруулсан) - тээврийн хэрэгсэл болон суурин объектын зориулалтын аль алинд нь ашиглагдах эрчим хүчний бүтээгдэхүүний татвар багтана. Тээврийн хэрэгсэлд ашиглагдах эрчим хүчний бүтээгдэхүүнд автобензин, дизелийн түлш болон түлшний бусад татварууд орно. Суурин объектод ашиглагдах эрчим хүчний бүтээгдэхүүнд түлшний тос/мазут, байгалийн хий, нүүрс болон цахилгаан эрчим хүч орно. Нүүрстөрөгчийн татвар нь эрчим хүчний татварт багтана.

Тээврийн татвар (тээврийн зориулалттай түлшийг оруулаагүй) - тээврийн хэрэгсэл эзэмших эрх болон ашиглалттай холбогдох татварууд багтана.

Байгаль орчны бохирдлын татвар - агаар, усны бохирдлын татвар болон хатуу хог хаягдлын татвар багтана.

Байгалийн нөөцийн татвар - ус, түүхий эд материал болон байгалийн бусад нөөцийн (элс, хайрга) олборлолтын татвар багтана. Байгаль орчны татварын ерөнхий хүрээнд нийцүүлэн Засгийн газарт төлөх газар ашиглалт болон байгалийн нөөц ашиглалтын төлбөрийг түрээсийн төлбөр гэж үзэх тул байгалийн нөөцийн татварын төрөлд хамруулахгүй.

Байгаль орчны татварт дараах татварууд хамаарахгүй. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Газрын баялгийн түрээстэй холбогдох татвар
- Архи, тамхи, түүнтэй төстэй бүтээгдэхүүний татвар болон нийгмийн даатгал, орлогын албан татварууд

Мэдээллийн эх үүсвэр

Байгаль орчны татварын дансыг байгуулахад Сангийн Яамны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Татварын Ерөнхий Газрын татвар төлөлтийн мэдээлэл, Гаалийн Ерөнхий Газрын татварын мэдээлэл болон Статистикийн бизнес регистр, эрчим хүчний биет урсгалын дансны мэдээллийг тус тус ашигласан.

Арга зүй

Байгаль орчны татварыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал болон өрхөд хуваарилахдаа үндэсний тооцоонд ашиглаж буй зарчмыг баримталж, татварыг эцсийн худалдан авагч буюу татвар ногдуулах бүтээгдэхүүнийг эзэмшигчдэд хуваарилсан.

Тархаалт

Байгаль орчны татварын дансны мэдээллийг статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ээс татаж авах боломжтой.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ҮР ДҮН

2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Монгол Улсын байгаль орчны татвар 2020 онд 919.4 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 1097.4 тэрбум төгрөг болж, 178.1 тэрбум төгрөг буюу 19.4 хувиар өссөн байна.

Татварын нийт орлогод байгаль орчны татварын эзлэх хувь 2018-2019 онд 10.4 хувь, 2020 онд 10.8 хувь байсан бол 2021 онд 9.7 хувь болсон байна.

ХҮСНЭГТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНСНААС ГАРАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2018-2021 он, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018	2019	2020	2021
Байгаль орчны татвар - НИЙТ	857.3	1 009.9	919.4	1 097.4
Эрчим хүчний татвар	356.2	409.5	381.6	414.0
Тээврийн татвар	333.7	380.2	318.7	409.4
Бохирдлын татвар	40.1	47.3	31.2	46.9
Байгалийн нөөцийн татвар	127.3	172.8	187.9	227.1
Нийт татварт байгаль орчны татварын эзлэх хувь	10.4	10.4	10.8	9.7
ДНБ-д байгаль орчны татварын эзлэх хувь	2.6	2.7	2.5	2.5

ЗУРАГ 1 . БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2015-2021 он



Байгаль орчны татварын орлогын бүтцээр авч үзвэл, 2018-2020 онд эрчим хүчний татварын эзлэх хувь 40.5-41.6 хувь байсан бол 2021 онд 37.7 хувь болж буурсан байна.

Эрчим хүчний татвар нь Монголд төдийгүй бусад олон оронд хамгийн их хувийг эзэлж байна. Татварын төрлөөр авч үзвэл, нийт байгаль орчны татварт эрчим хүчний татвар 2021 онд 37.7 хувь, тээврийн татвар 37.3 хувь, байгалийн нөөцийн татвар 20.7 хувь, байгаль орчны бохирдлын татвар 4.3 хувийг эзэлж байна.

2.1.1. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР

Эрчим хүчний татварт автобензин, дизелийн түлшний татвараас гадна автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр багтана.

Эрчим хүчний татвар 2021 онд 414.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 32.5 тэрбум төгрөг буюу 8.5 хувиар өссөн байна. Эрчим хүчний татварын 95.7 хувийг автобензин, дизелийн түлшний онцгой болон импортын албан татвар эзэлж байна.

ХҮСНЭГТ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг


Татварын төрөл	2018	2019	2020	2021
Эрчим хүчний татвар - НИЙТ	356.2	409.5	381.6	414.0
АДТ-ний албан татвар	13.1	16.4	17.1	16.6
АДТ-ний импортын гаалийн албан татвар	127.7	131.0	111.0	155.9
АДТ-ний онцгой албан татвар	213.5	260.3	252.8	240.4
АТӨЯХ-ийн агаарын бохирдлын төлбөр	2.0	1.9	0.7	1.1

Дотоодын зах зээлд автобензин, дизелийн түлшний үнийг тогтвортой байлгах зорилгоор 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа 2017 онд 3 удаа, 2018 онд 1 удаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварт өөрчлөлт оруулсан. Түлш, эрчим хүчний бүтээгдэхүүний импортын биет хэмжээг авч үзэхэд 2021 онд өмнөх оноос онгоцны түлш 43.2 хувиар өсөж, харин автобензин 2.3 хувиар, дизель түлш 3.7 хувиар, түлшний мазут 35.7 хувиар, тослох материал 59.7 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ТҮЛШНИЙ ИМПОРТ, 2018-2021 он, мянган тонн

Төрөл	2018	2019	2020	2021
Автобензин	435.2	541.5	586.1	572.7
Дизелийн түлш	848.8	1 080.4	1 026.9	988.9
Онгоцны түлш	40.3	46.6	19.2	27.5
Түлшний мазут	3.0	3.0	2.8	1.8
Тослох материал	439.8	114.4	71.5	28.8

ЗУРАГ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАТВАР, ТҮЛШНИЙ ИМПОРТ, 2015-2021 он (2015=100)



Автобензин, дизелийн түлшний импортын гаалийн албан татвар 2021 онд 155.9 тэрбум төгрөгт хүрч 2015 оноос 2.6 дахин өссөн байна. Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 2021 онд 240.4 тэрбум төгрөг болж 2015 оноос 13.9 хувиар буурсан байна.

Энэ нь "Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай" хуульд 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан буюу онцгой албан татварын хэмжээг бууруулсантай холбоотой юм. Дизелийн түлшний импорт 2021 онд 2015 оноос 51.0 хувь, автобензиний импорт 32.1 хувь, эрчим хүчний татварын орлого 17.6 хувиар өссөн байна.

2.1.2. ТЭЭВРИЙН ТАТВАР

Тээврийн татварт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар, суудлын автомашины онцгой албан татвар багтана. Тээврийн татвар 2021 онд 409.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 90.6 тэрбум төгрөг буюу 28.4 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд 2021 онд суудлын автомашины импорт өмнөх оноос 2.2 мянган ширхгээр буюу 4.1 хувиар, ачааны автомашины импорт өмнөх оноос 5.5 мянган ширхгээр буюу 26.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 4. ТЭЭВРИЙН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг

Татварын төрөл	2018	2019	2020	2021
Тээврийн татвар	333.7	380.2	318.7	409.4
АТӨЯХ-ийн албан татвар	38.3	41.2	45.9	53.4
Тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар	81.2	106.6	100.5	153.3
Суудлын автомашины онцгой албан татвар	214.2	232.4	172.3	202.6


Тээврийн татварын 87.0 хувийг тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар, суудлын автомашины онцгой албан татвар эзэлж байна. Тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар 2021 онд өмнөх оноос 52.5 хувиар, суудлын автомашины онцгой албан татвар 17.6 хувиар тус тус өссөн байна.

Импортоор оруулсан суудлын автомашины онцгой албан татвар 2017 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн дараах байдлаар нэмэгдсэн. Үүнд:

- 4500 см³-аас доош хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд ашиглагдсан хугацаанаас шалтгаалж 3.4-15.5 хувь
- 4501 см³-аас дээш хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд ашиглагдсан хугацаанаас шалтгаалж 40 хувиас 3.5 дахин

Харин хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашиныг онцгой албан татвараас 100 хувь чөлөөлж байсныг 0-50 хувиар ногдуулахаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

ЗУРАГ 3. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, ТЭЭВРИЙН ТАТВАР, 2015-2021 он (2015=100)



Импортоор оруулсан тээврийн хэрэгсэл 2015 онд 46.7 мянга байсан бол 2021 онд 85.0 мянга, үүнээс суудлын автомашин 2015 онд 37.1 мянгыг импортоор оруулсан бол 2021 онд 55.2 мянга болжээ. Харин тээврийн татварын орлого 2015 онд 83.0 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 409.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Импортоор оруулсан тээврийн хэрэгсэл 2021 онд 2015 оноос 82.1 хувь, үүнээс суудлын автомашины импорт 48.9 хувь, харин татварын орлого 4.9 дахин өссөн байна.

2.1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР

Байгаль орчны бохирдлын татварт нүүрсний агаарын бохирдлын төлбөр, органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр, томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөр,

усны бохирдлын төлбөр багтана. Байгаль орчны бохирдлын татвар 2021 онд 46.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 15.7 тэрбум төгрөг буюу 50.5 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг

Татварын төрөл	2018	2019	2020	2021
Байгаль орчны бохирдлын татвар	40.1	47.3	31.2	46.9
Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	40.1	47.3	31.2	46.9
Органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Усны бохирдлын төлбөр	0.0	0.0	0.0	0.0

Байгаль орчны бохирдлын татварын 99.9 хувийг нүүрсний агаарын бохирдлын төлбөр эзэлж байна. Нүүрсний агаарын бохирдлын төлбөрийг олборлосон түүхий нүүрсний тонн тутамд ногдуулдаг.

Нүүрсний олборлолт 2021 онд 30.1 сая тонн болж, 2015 оноос 24.5 хувиар нэмэгджээ. Харин байгаль орчны татвар, хураамж 2021 онд 46.9 тэрбум төгрөг болж, 2015 оноос 3.8 дахин өсжээ.

ЗУРАГ 4. НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАТВАР, 2015-2021 он (2015=100)



2.1.4. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТАТВАР

Байгалийн нөөцийн татварт агнуурын нөөц ашигласны төлбөр, ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр, ургамал ашигласны төлбөр, ус, рашаан ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр багтана.

Байгалийн нөөцийн татвар 2021 онд 227.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 39.3 тэрбум төгрөг буюу 20.9 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд газрын төлбөр өмнөх оноос 20.2 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр өмнөх оноос 28.1 хувь, агнуурын нөөц ашигласны төлбөр 11.4 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 6. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТАТВАР, 2018-2021 он, тэрбум төгрөг

Татварын төрөл	2018	2019	2020	2021
Байгалийн нөөцийн татвар	127.3	172.8	187.9	227.1
Агнуурын нөөц ашигласны төлбөр	5.6	7.2	1.1	13.0
Ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр	4.1	3.6	13.5	15.1
Ургамал ашигласны төлбөр	0.5	0.2	4.2	1.7
Ус, рашаан ашигласны төлбөр	46.7	47.8	45.1	48.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3.6	3.7	4.2	5.4
Газрын төлбөр	66.8	110.3	119.7	143.9

2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАР, ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР

Аж ахуйн нэгж, байгууллага болон өрхийн төлсөн татварын хэмжээ татварын төрлөөс хамааран ялгаатай байдаг.


ХҮСНЭГТ 7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАР, татварын орлогын төрөл, татвар төлөгчөөр, 2021 он

Татварын төрөл	Нийт дүн	Өрх	Салбар	Үүнээс:				Нийт ТА-д эзлэх хувь	ДНБ-д эзлэх хувь
				Хөдөө аж ахуй	Уул уурхай, олборлолт	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		
Байгаль орчны татвар- НИЙТ	1 097.4	412.8	684.7	10.8	311.8	65.1	297.0	9.7	2.5
Эрчим хүчний татвар	414.0	143.3	270.7	3.4	182.0	12.1	73.3	3.7	1.0
Тээврийн татвар	409.4	259.2	150.1	1.2	5.2	7.7	136.0	3.6	0.9
Байгаль орчны бохирдлын татвар	46.9	-	46.9	-	32.6	12.4	2.0	0.4	0.1
Байгалийн нөөцийн татвар	227.1	10.2	216.9	6.3	92.0	32.8	85.8	2.0	0.5

Байгаль орчны татварын гол төрөл болох эрчим хүчний татварыг 2015 онд 42.3 хувийг өрх, 27.0 хувийг уул уурхай, олборлолтын салбар бүрдүүлж байсан бол уул уурхай, олборлолтын үйл ажиллагаа идэвхэжсэнээр 2021 онд 34.6 хувийг өрх, 43.9 хувийг уул уурхай, олборлолтын салбараас бүрдүүлжээ.

Тээврийн татварын ихэнх хувийг өрхүүд төлж байна. Өрх 2015 онд тээврийн татварын 62.8 хувийг бүрдүүлж байсан бол 2021 онд 63.3 хувь болсон байна. Байгалийн нөөцийн татварын 50-иас дээш хувийг үйлдвэрлэлийн салбар төлж байна.


ЗУРАГ 5. ЭРЧИМ ХҮЧ, ТЭЭВРИЙН ТАТВАР, татвар төлөгчөөр, дүнд эзлэх хувиар



2.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАРАМТ

Монгол Улсад байгаль орчны татварын статистикийг хөгжүүлснээр төсвийн орлогод "ногоон" татварын эзлэх хувийг тодорхойлох, ногоон татварын шинэчлэлийн явцыг хянах боломж бий болох юм.

ЗУРАГ 6. НИЙТ ТАТВАР, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, 2015-2021 он



Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь нь татварын ачаалал хэр байгааг харуулах үзүүлэлт бөгөөд Монгол Улсын хувьд нийт татварын ачаалал 2021 онд өссөн хэдий ч байгаль орчны татварын ачаалал тогтмол түвшинд байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын байгаль орчны татварын хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2021 онд 1097.4 тэрбум төгрөг болж, 2015 оноос 97.4 хувиар өссөн байна.

Байгаль орчны татвар 2021 онд татварын нийт орлогын 9.7 хувийг бүрдүүлжээ. Үүнд, эрчим хүчний татвар 6.1 нэгж хувь, тээврийн татвар 1.5 нэгж хувь, байгалийн нөөцийн татвар 1.9 нэгж хувь, байгаль орчны бохирдлын татвар 0.2 нэгж хувийг эзэлж байна.

Байгаль орчны татварын ачаалал 2015-2021 онд дунджаар 2.5 хувь байна. Байгаль орчны татварын 62.4 хувийг аж ахуйн нэгж, байгууллагууд, 37.6 хувийг иргэд төлж байна.

Байгаль орчны татварын ихэнх хувийг эрчим хүчний татвар эзэлдэг бөгөөд 2016 оны байдлаар 65.1 хувь, 2018 онд 41.6 хувь, 2020 онд 41.5 хувь, 2021 онд 37.7 хувь байна.

Монгол Улсын түлшний импортын 2021 оны хэмжээг 2015 онтой харьцуулахад дизелийн түлшний импорт 51.0 хувиар, автобензиний импорт 32.1 хувиар тус тус өссөн байна.

Тээврийн татвар 2021 онд 409.4 тэрбум төгрөгт хүрч, 2015 оноос 4.9 дахин, 2020 оноос 28.4 хувиар нэмэгджээ. Үүнд суудлын автомашины онцгой албан татвар, тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар өссөн нь голлон нөлөөлжээ.

Байгаль орчны бохирдлын татвар 2021 онд 46.9 тэрбум төгрөгт хүрч, 2015 оноос 3.8 дахин, 2020 оноос 50.5 хувиар өссөн байна. Байгаль орчны бохирдлын татварын 99.9 хувийг нүүрсний агаарын бохирдлын төлбөр эзэлж байна. Нүүрс олборлолт 2021 онд 30.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 31.3 хувиар буурсан байна.

Байгалийн нөөцийн татвар 2021 онд 227.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 39.3 тэрбум төгрөг буюу 20.9 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд газрын төлбөр өмнөх оноос 20.2 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 28.1 хувь, агнуурын нөөц ашигласны төлбөр 11.4 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ТӨРӨЛД ХАМААРАХ ТАТВАРЫН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын жагсаалт	Байгаль орчны татварын төрөл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	
Татварын орлого	
Орлогын албан татвар	
Нийгмийн даатгалын орлого	
Хөрөнгийн албан татвар	
Үл хөдлөх хөрөнгийн татвар	
Бууны татвар	
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Т
Малд ногдуулах албан татвар	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	
Онцгой албан татвар	
Дотоодын архины	
Дотоодын тамхины	
Автобензин, дизель түлшний	Э
Импортын архи	
Импортын тамхины	
Импортын пивоны	
Суудлын автомашины	Т
Дотоодын пивоны онцгой	
Тусгай зориулалтын орлого	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	Э
Гадаад үйл ажиллагааны орлого	
Импортын гаалийн албан татвар	
Тээврийн хэрэгслийн импортын гаалийн албан татвар	Т
Автобензин, дизелийн түлшний импортын гаалийн албан татвар	Э
Экспортын гаалийн албан татвар	
Бусад татвар (Төлбөр, хураамж)	
Бусад нийтлэг төлбөр, хураамж	
Улсын тэмдэгтийн хураамж	
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	
Агаарын бохирдлын төлбөр болон бусад татвар хураамж	Б/Э
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	Н
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр	
Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	
Ус бохирдуулсны төлбөр	Б
Улсын төсвийн хөрөнгөөр тогтоосон усны нөөцийн зардлын нөхөн төлбөр	
Гаалийн тэмдэгтийн хураамж	
Бусад татвар	
Газрын төлбөр	Н
Байгалийн нөөц ашигласны төлбөр	
Ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр	Н
Агнуурын нөөц ашигласны төлбөр	Н
Рашаан, ус ашигласны төлбөр	Н
Байгалийн ургамал ашигласны төлбөр	Н
Бусад татвар	
Татварын бус орлого	

1Б-Байгаль орчны бохирдлын татвар, Н-Байгалийн нөөцийн татвар

Т-Тээврийн татвар, Э-Эрчим хүчний татвар

Б/Э-АТӨЯХ-ийн агаарын бохирдлын төлбөр нь эрчим хүчний татварт орох бөгөөд үлдсэн татвар нь байгаль орчны бохирдлын татварт орно.

ХҮСНЭГТ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАТВАРЫН ДАНС, 2021 он, сая төгрөг

Татварын төрөл	Нийт дүн	Өрх	Салбар	Үүнээс:			
				Хөдөө аж ахуй	Уул уурхай, олборлолт	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
А	Б=В+Г	В	Г=Д+Е+Ё+Ж	Д	Е	Ё	Ж
Байгаль орчны татвар	1 097 442.6	412 782.0	684 660.6	10 836.9	311 750.6	65 075.5	296 997.7
Эрчим хүчний татвар	414 021.3	143 306.4	270 714.9	3 355.5	181 955.2	12 130.2	73 274.0
Авто бензин, дизелийн түлшний албан татвар	16 597.7	9 559.8	7 037.9	74.1	2 689.1	573.2	3 701.6
Авто бензин, дизелийн түлшний импортын гаалийн албан татвар	155 917.4	64 762.9	91 154.5	1 058.9	59 166.3	4 850.7	26 078.7
Авто бензин, дизель түлшний онцгой албан татвар	240 442.7	68 269.4	172 173.3	2 219.7	120 056.0	6 650.3	43 247.3
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр	1 063.5	714.4	349.2	2.8	43.9	56.1	246.4
Тээврийн татвар	409 356.9	259 241.7	150 115.2	1 217.7	5 175.7	7 733.3	135 988.5
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	53 407.1	32 373.8	21 033.3	164.5	1 832.4	2 182.7	16 853.8
Суудлын авто машины импортын гаалийн албан татвар	153 320.2	54 954.8	98 365.5	944.5	3 340.9	5 064.4	89 015.7
Суудлын авто машины онцгой албан татвар	202 629.5	171 913.1	30 716.4	108.6	2.4	486.3	30 119.1
Бохирдлын татвар	46 920.9	-	46 920.9	-	32 595.7	12 370.4	1 954.7
Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	46 885.4	-	46 885.4	-	32 595.7	12 353.7	1 935.9
Органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр	35.5	-	35.5	-	-	16.7	18.8
Томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөр	-	-	-	-	-	-	-
Байгалийн нөөцийн татвар	227 143.6	10 234.0	216 909.6	6 263.6	92 023.9	32 841.6	85 780.5
Агнуурын нөөцийн төлбөр	12 987.6	3 254.0	9 733.6	-	-	-	9 733.6
Ойн нөөцийн төлбөр	15 057.0	4 273.5	10 783.5	3 730.4	-	5 254.1	1 799.0
Ургамал ашигласны төлбөр	1 693.2	23.7	1 669.5	47.4	-	1 031.4	590.8
Ус, рашаан ашигласны төлбөр	48 130.2	97.2	48 033.0	31.4	42 437.7	3 946.9	1 616.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5 408.8	648.1	4 760.7	26.6	1 642.9	479.4	2 611.7
Газрын төлбөр	143 866.8	1 937.4	141 929.4	2 427.8	47 943.3	22 129.8	69 428.5

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ҮСХ "Байгаль орчны татварын дансыг байгуулах аргачлал", 2018

ҮСХ "Байгаль орчны татварын данс 2020" танилцуулга

ҮСХ, АХБ "Монгол Улсын Байгаль орчин-эдийн засгийн зарим дансууд", 2018

Байгаль орчин-эдийн засгийн дансны систем 2012 Ерөнхий хүрээ

Eurostat, Environmental taxes, A statistical guide, 2013

Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2021

Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2021

Сангийн яам, Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, 2021

<http://www.1212.mn/>